UAF A&P | Яаралтай ажиллагааны тэтгэлэг олгох хөтөлбөр

# ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ

## А. ТЭТГЭЛГИЙН ТӨРӨЛ

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ**

Энэхүү тэтгэлэг нь эрүүл, аюулгүй байдлыг хангахад нэн шаардлагатай, хойшлуулах аргагүй арга хэмжээ авахад зориулж Ази, Номхон далайн бүс нутаг дахь хүний эрхийн хамгаалагч эмэгтэй болон нон-байнари[1] хувь хүн эсвэл байгууллагад олгодог санхүүгийн дэмжлэг юм. Энэ нь эмэгтэйчүүдийн эрх, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны үед хүний эрхийн хамгаалагчид тулгарч буй заналхийлэл эсвэл хямралт, түгшүүрт, эрсдэлт нөхцөл байдалд орсон хувь хүн, байгууллагад зориулсан тэтгэлэг юм. Мөн тус дэмжлэгийг сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэцийн гэмтэл засал болон эрүүл мэндийн тусламж зэрэг эрүүл, аюулгүй байдалд нь нэн тулгамдаж буй хэрэгцээ шаардлагад ашиглаж болно.

## Б. ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ

Цахим хуудсаар (www.uafanp.org) ЭСВЭЛ цахим шуудангаар (grants@uafanp.org) өргөдлөө илгээнэ үү.

## В. ТЭТГЭЛГИЙН ШАЛГУУР

1. **Эмэгтэйчүүд эсвэл нон-байнари хүмүүс удирддаг байх** – тэтгэлгийн гол үр шим хүртэгч нь хүний эрхийг хамгаалагч эмэгтэй эсвэл нон-байнари[1] хүмүүс байх шаардлагатай ба санхүүжилтийг эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллагаар дамжуулж олгохыг илүүд үзнэ;
2. **Хүний эрхэд чиглэсэн байх** – тус байгууллага нь хүчирхийллийн бус арга зам, стратеги ашиглаж, хүний эрхийн түгээмэл шинж чанарыг эрхэмлэх замаар эмэгтэйчүүдийн болон/эсвэл ЛГБТКИ хүмүүсийн хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэдэг байх;
3. **Таамаглаагүй болон/эсвэл хойшлуулах аргагүй** – Хариу арга хэмжээ авах гэж буй түгшүүрт эсвэл онцгой нөхцөл байдал, үйл явдал нь тухайн хамгаалагч эсвэл байгууллагыг эрсдэлт байдалд оруулж буй;
4. **Эрүүл, аюулгүй байдалд нь дэмжлэг болох** – Тус тэтгэлэг нь тухайн хамгаалагч эсвэл байгууллагын аюулгүй байдлыг хангахад (жишээ нь эрх зүйн тусламж, нүүлгэн шилжүүлэлт, аврах ажиллагаа, эрсдэлийн үнэлгээ болон сургалт, хамгаалалтын хэрэгсэл) болон/эсвэл эрүүл мэндийн хэрэгцээнд (жишээ нь сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэцийн гэмтэл засал болон эрүүл мэндийн тусламж) зориулсан байх шаардлагатай;
5. **Хямралт байдлын үед эсвэл дараа нь нэн даруйд** – Хүсэж буй тэтгэлэг нь хямралт байдлын үед эсвэл дараа нь нэн даруйд тухайн хамгаалагч эсвэл байгууллагын эрүүл, аюулгүй байдлыг дэмжихэд зориулсан байх шаардлагатай;
6. **Дэмжлэгтэй эсвэл дэмжлэгийн сүлжээтэй байх** – Тухайн хамгаалагч эсвэл байгууллага нь орон нутгийн эсвэл үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн хүний эрх, бэлгийн эрх эсвэл хүний эрхийн бусад салбарын оролцогчдын дэмжлэгтэй байх.

---

1 ***Нон-байнари*** *гэдэг нь эрэгтэй, эмэгтэй, эр, эм зэрэг нэр томьёоны аль нэгээр нь жендэрээ тодорхойлдоггүй эсвэл илэрхийлдэггүй хүмүүсийг ойлгох ерөнхий нэр томьёо буюу жендэрийн хоёрдмол, сизнорматив илэрхийллээс гадуурх хүмүүсийг хэлнэ. Ази, Номхон далайн ЯТС нь энэ нэр томьёогоор андрогини, полижендэр, жендэркүйир, жендэрийн баригдмал бус болон эй-жендэр хүмүүсийг мөн хамруулан ойлгодог.*

URGENT ACTION FUND FOR WOMEN'S HUMAN RIGHTS ASIA & PACIFIC

UAF A&P | Яаралтай ажиллагааны тэтгэлэг олгох хөтөлбөр

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

**Тэтгэлэг нь доорх нөхцөлд хамаарахгүй:**

- Сизжендэр эрэгтэй[2], сизжендэр эрэгтэйчүүдийн удирдсан байгууллага эсвэл сүлжээ;
- Аль нэг байгууллага, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хүрээлэл, сүлжээ, эсвэл Ази, Номхон далайн ЯТС[3]-гийн зөвлөхөөс баталгаа, дэмжлэг аваагүй хүсэлтүүд;
- Хүмүүнлэгийн хямрал, байгалийн гамшигт чиглэсэн үйл ажиллагаа эсвэл төсөл;
- Хөгжлийн дэмжлэг, хандивын тусламжид чиглэсэн үйл ажиллагаа эсвэл төсөл;
- Аливаа байгууллагын байнгын хэрэгжүүлдэг хөтөлбөрийн аль нэг төсөл эсвэл үйл ажиллагаа;
- Ердийн үйл ажиллагааны төсөв болон/эсвэл завсрын санхүүжилт (төсвийн зөрүүг нөхөх).

## Г. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АЮУЛГҮЙ СУВАГ

Яаралтай ажиллагаанд зориулсан тэтгэлэг олгох энэхүү хөтөлбөрийн гол цөм нь өргөдөл гаргагч, тэтгэлэг хүртэгчдийн аюулгүй, халдашгүй байдал гэж Ази, Номхон далайн ЯТС үздэг. Тиймээс харилцаа холбооны аюулгүй бөгөөд нууцлалтай суваг ашиглах нь үүний нэг хэсэг юм. Тус байгууллага нь харилцаа холбооны зөвхөн дараах төрөл болон түүнд хамаарах хэрэгслийг хүлээн зөвшөөрдөг болно:

- Цахим шуудpoints, ProtonMail https://protonmail.com/signup
- Мессеж харилцаанд, Signal апп https://signal.org

Манай байгууллагатай харилцахдаа эдгээр хэрэгслүүдэд хаяг нээж харьцахыг хичээнгүйлэн зөвлөж байна. Хаяг нээхэд 10 минут л шаардлагатай. Эдгээр аюулгүй хэрэгсэлд хаяг нээхэд туслалцаа хэрэгтэй бол манай Мэдээллийн технологийн ажилтан Эстертэй холбогдоно уу: esther@uafanp.org

## I. ХАРИЛЦАХ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Хүсэлт гаргагч хүний нэр: | |
| Байгууллага эсвэл харьяа сүлжээ/хүрээллийн нэр (Санхүүжилт авахад байгууллага/сүлжээ эсвэл батлан даагч байх шаардлагатай) | |
| Албан тушаал | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Шуудангийн хаяг: | Хаяг | | | |
| | Дүүрэг/сум | Хот/аймаг | Улс | Шуудангийн код |

| | | | |
|---|---|---|---|
| Харилцах хаяг: | Цахим шуудан | Гар утас | |
| | Суурин утас | Signal хаяг | WhatsApp хаяг |

2 *Сизжендэр эрэгтэй гэдэг нь өөрийгөө эрэгтэй гэж тодорхойлдог бөгөөд төрөхөд оноосон хүйс нь эр хүмүүсийг хэлнэ.*
3 *ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН САН (ЯТС) АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ*

UAF A&P | Яаралтай ажиллагааны тэтгэлэг олгох хөтөлбөр

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

| | | |
|---|---|---|
| Цахим хуудас, нийгмийн сүлжээ (байгаа тохиолдолд) | Вэбсайт/Цахим хуудас | Facebook |
| | Twitter | Бусад |

| | |
|---|---|
| 2. Энэ хүсэлтийг та өөрийнхөө эсвэл байгууллагынхаа өмнөөс гаргаж байна уу? Эсвэл өөр хүн, өөр байгууллагын өмнөөс гаргаж байна уу? | ○ Өөрийнхөө эсвэл байгууллагынхаа өмнөөс (Тийм бол 3, 3А, 3Б асуултыг алгасна уу)<br>◉ Өөр хүн эсвэл өөр байгууллагын өмнөөс (Тийм бол 3, 3А, 3Б асуултад хариулна уу) |

3. Хэрэв энэ хүсэлтийг өөрөөсөө бусад хүн эсвэл байгууллага/сүлжээ/хүрээллийн өмнөөс гаргаж байгаа бол нэрийг нь доор бичнэ үү. (Өөр хүн, байгууллага эсвэл сүлжээ/хүрээллийн өмнөөс хүсэлт гаргаагүй бол энэ асуултыг алгасна уу.)

| | | |
|---|---|---|
| 3A. Хувь хүний өмнөөс | Хувь хүний нэр | |
| | Цахим шуудан | Утас |

| | | |
|---|---|---|
| 3B. Байгууллагын өмнөөс | Байгууллага эсвэл сүлжээний нэр | |
| | Харилцах хүний нэр | |
| | Цахим шуудан | Утас |

## II. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

**1. Байгууллага эсвэл сүлжээний зорилго болон зорилт:**

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

| | | | |
|---|---|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | ☐ Иргэний болон улс төрийн эрх | ☐ Хууль, эрх зүйн тогтолцоо | ☐ Нийгэм, эдийн засгийн эрх / Эдийн засгийн шударга ёс |
| | ☐ Цаг уурын өөрчлөлт / Байгаль орчны шударга ёс | ☐ ЛГБТКИ / Бэлгийн чиг баримжаа, жендэрийн тодорхойлолт ба илэрхийлэмж | ☐ Хүний наймаа |
| | ☐ Зөрчил мөргөлдөөн / Энх тайвныг бэхжүүлэх | ☐ Шилжин суурьшигчдын эрх | ☐ Хот суурин газрын ядуурал / Ядуусын хорооллын оршин суугчид |
| | ☐ Цахим аюулгүй байдал / Мэдээлэл, харилцаа холбооны технологи | ☐ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд | ☐ Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл / Жендэрт суурилсан хүчирхийлэл |
| | ☐ Үндэстний цөөнх | ☐ Тариачин / орон нутгийн эмэгтэйчүүд | ☐ Эмэгтэйчүүдийн хүний эрх |
| | ☐ Албадан нүүлгэлт / Дотоод дүрвэгсэд | ☐ Улс төрийн оролцоо | ☐ Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагчид |
| | ☐ Эрүүл мэнд, хүний сайн сайхан байдал | ☐ Дүрвэгсэд / Харьяалалгүй хүмүүс | ☐ Залуус / Залуу эмэгтэйчүүд |
| | ☐ ХДХВ/ДОХ | ☐ Шашны цөөнх | Бусад: |
| | ☐ Хүний эрх | ☐ Ахмад иргэд | |
| | ☐ Уугуул иргэд | ☐ Бэлгийн хөдөлмөр эрхлэгч | |
| | ☐ Хөдөлмөрийн эрх | ☐ Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх | |
| | ☐ Газрын эрх | | |

**2. Гол шийдвэр гаргагчид ба жендэрийн бүтэц:**

| Танай байгууллага/сүлжээний гол шийдвэр гаргагчид хэн бэ? | Нэр | Албан тушаал | Жендэрийн тодорхойлолт |
|---|---|---|---|
| | 1. | | |
| | 2. | | |
| | 3. | | |

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

## 3. Тодорхойлолт гаргагч/Батлан даагч:

| | | |
|---|---|---|
| Танай үйл ажиллагааг дэмжиж тодорхойлолт өгөх дор хаяж 2 хүний нэр, холбогдох хаягийг бичнэ үү. Тухайн хүмүүст урьдчилан мэдэгдэж хариу өгөх хангалттай хугацаа өгөхийг зөвлөж байна. | 1. Тодорхойлолт гаргагчийн нэр | Харьяа байгууллага/сүлжээний нэр |
| | Цахим шуудан | Утас |
| | Өргөдөл гаргагчтай ямар харилцаатай эсэх (Тухайн хүнийг хэрхэн таньдаг вэ?): | |
| | 2. Тодорхойлолт гаргагчийн нэр | Харьяа байгууллага/сүлжээний нэр |
| | Цахим шуудан | Утас |
| | Өргөдөл гаргагчтай ямар харилцаатай эсэх (Тухайн хүнийг хэрхэн таньдаг вэ?): | |

## 4. Донор дэмжигч:

| | | |
|---|---|---|
| Хэрэв хамааралтай бол (сүүлийн 2 жилийн хугацаанд) санхүүжилт олгосон 1-2 санхүүжүүлэгч болон харилцах хаягийг нь бичнэ үү. | 1. Санхүүжүүлэгчийн нэр | |
| | Цахим шуудан | Утас |
| | 2. Санхүүжүүлэгчийн нэр | |
| | Цахим шуудан | Утас |

## 5. Ази, Номхон далайн ЯТС-гийн талаар мэдээлэл авсан суваг

ЯТС эсвэл Ази, Номхон далайн ЯТС-гийн талаар хаанаас мэдээлэл авсан бэ? Хамаарах бүх сонголтыг сонгоно уу.

- ☐ Интернэтийн хайлт / Ази, Номхон далайн ЯТС
- ☐ Нийгмийн сүлжээ
- ☐ Имейл жагсаалт, групп
- ☐ Урьд нь ЯТС-гаас санхүүжилт, тэтгэлэг авч байсан
- ☐ Бусад:
- ☐ Ази, Номхон далайн ЯТС-гийн зөвлөх
- ☐ Ази, Номхон далайн ЯТС-гийн ажилтан
- ☐ Хамтран ажиллагч, хамт олон
- ☐ Урьд нь Ази, Номхон далайн ЯТС-д хүсэлт тавьсан ч санхүүжилт аваагүй

## III. ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ АСУУЛТУУД (ХАРИУЛАХ ШААРДЛАГАТАЙ)

**ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД**: Эдгээр **ЧИГЛҮҮЛЭХ** асуултууд нь Эрүүл, Аюулгүй байдлыг хангах тэтгэлэг хүсэх шаардлага танд бий эсэхийг тодорхойлоход тусална. Дараах асуултуудын аль нэгэнд нь ТИЙМ гэж хариулсан бол доорх 1-10-р асуултад хариулна уу.

- Хүний эрхийн үйл ажиллагааныхаа улмаас та (болон/эсвэл танай гэр бүл, хамтран ажиллагч, байгууллага) заналхийлэл, халдлагад өртсөн эсвэл эрүүл мэнд, амь насанд тань аюул занал учирч байна уу?
- Таныг аюулгүй орчин руу нүүлгэн шилжүүлэх, аврах ажиллагаа явуулах шаардлагаар санхүүжилт хүсэж байна уу?
- Та ажлын байр эсвэл гэрийнхээ аюулгүй байдал, хамгаалалтыг сайжруулахад зориулж санхүүжилт хүсэж байна уу? (тоноглол, зэвсэггүй бие хамгаалагч, цахим аюулгүй байдлын технологи)
- Дээрх аюулгүй байдлыг хангах арга хэмжээнээс гадна та эрх зүйн тусламж, цагдан хоригдсон үеийн дэмжлэг, эмчилгээ (сэтгэл зүй, гэмтэл засал), гэр бүлээ дэмжих, эсвэл дээр дурдагдаагүй өөр дэмжлэг авах шаардлагаар санхүүжилт хүсэж байна уу?
- Дээр дурдагдаагүй эрүүл, аюулгүй байдлын өөр шаардлагаар санхүүжилт хүсэж байна уу?

| | |
|---|---|
| 1. Эмэгтэйчүүдийн болон ЛГБТКИ+ хүмүүсийн эрхийг ахиулах, хамгаалахад чиглэсэн активизмын өөрийн (эсвэл өмнөөс нь хүсэж буй хүн/ байгууллага/сүлжээ/хүрээллийн) түүхийг товч бичнэ үү. | |
| 2A. Танд эсвэл танай байгууллага/сүлжээ/хүрээлэлд тулгарч буй эрсдэл, аюулыг тайлбарлана уу. (Боломжтой бол холбогдох нийтлэл, хэвлэлийн мэдээллийн холбоосыг хавсаргана уу.) | |

<table>
<tr><td rowspan="4">2Б. Танд эсвэл танай байгууллагад хамаарах хүний эрхийн бүх зөрчлийг сонгоно уу.</td><td>I. Амь нас, бие, сэтгэл санааны бүрэн байдалд халдах<br>☐ Амь насыг бүрэлгэх, алахыг завдах<br>☐ Сураггүй алга болох<br>☐ Эрүү шүүлт тулгах: хэрцгий, хүмүүнлэг бус, доромжлон харьцах<br>☐ Хүчин, бэлгийн халдлага, зүй бус харьца<br>☐ Гэр бүлийн хүчирхийлэл<br>☐ Хүч хэтрүүлэн хэрэглэх<br>☐ Бусад:</td></tr>
<tr><td>II. Бие, сэтгэл санааны эрх чөлөөг боомилох<br>☐ Дур зоргоор баривчлах, саатуулах<br>☐ Хугацаа хэтрүүлэн хорьж саатуулах<br>☐ Хүн хулгайлах<br>☐ Сэтгэцийн эрүүл мэндийн шалтгаанаар цагдан хор<br>☐ Бусад:</td></tr>
<tr><td>III. Хүн чанар, нэр төрд халдах<br>☐ Заналхийлэх, сануулах, тулган шаардах<br>☐ Сэтгэл зүйн хүчирхийлэл<br>☐ Сүрдүүлэх, сүрдүүлэн мөнгө г.м. шаардах<br>☐ Бэлгийн хүчирхийлэл<br>☐ Жендэр, сэксуалити-г өгөөш болгон ашиг<br>☐ Гүтгэх, гүжирдэх, шоглох, нэр төр гутаах ажиллагаа явуулах<br>☐ Үзэн ядах үг хэллэг ашиглах<br>☐ Гутаах, ялгаварлах, гадуурхах<br>☐ Бусад:</td></tr>
<tr><td>IV. Хувийн халдашгүй байдал, харилцаанд халдах зөрчил<br>☐ Ажлын байр, гэрт нэгжлэг явуулах<br>☐ Гэр бүл, хамт олонд халдах, сүрдүүлэх<br>☐ Бусад:</td></tr>
</table>

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

| | |
|---|---|
| | V. Эмэгтэй болон жендэрийн хэвшмэл байдалд үл хамаарах хувь хүний активизмыг хязгаарлаж буй хууль, эрх зүйн заалт, үйл ажиллагаа<br>☐ Шашинд үндэслэсэн, уламжлалт хууль, эрх зүйн орчныг ашиглан эрх хязгаарлах<br>☐ Гэмт хэрэгжүүлж яллах<br>☐ Хууль бусаар мөрдөх, байцаах, хянах, хар дансанд оруулах<br>☐ ТББ-ын эсрэг боловсруулсан хууль<br>☐ Ажлын байран дахь хориг, хязгаарлалт<br>☐ Бусад: |
| 2Б. Танд эсвэл танай байгууллагад хамаарах хүний эрхийн бүх зөрчлийг сонгоно уу. | VI. Эмэгтэйчүүдийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран цугларах эрх чөлөөг зөрчих<br>☐ Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах<br>☐ Санхүүжилт авах эрхийг хязгаарлах<br>☐ Үг хэлэх эрх чөлөөг хязгаарлах<br>☐ Мэдээлэл авах эрхийг хязгаарлах<br>☐ Олон улсын байгууллагатай харьцахыг хязгаарлах<br>☐ Хуран цугларах эрх чөлөөг хязгаарлах<br>☐ Бусад:<br><br>VII. Чөлөөтэй зорчих эрхийг жендэрт үндэслэн хязгаарлах<br>☐ Гадаад руу зорчихыг хязгаарлах, зөвшөөрөл авахыг шаардах<br>☐ Хөдөлгөөнийг хязгаарлах, саад болох<br>☐ Аялах визийг хязгаарлах<br>☐ Хилээр албадан гаргах<br>☐ Бусад:<br><br>VIII. Зөрчлийг үл тоох, хариуцлага тооцохгүй байх байдал. Доор тайлбарлана уу. |

| | |
|---|---|
| 3. Халдлага үйлдэгч нь таны ойлголтоор хэн бэ? | **Төрийн этгээд** (Жишээ нь цагдаа, хууль сахиулагч, цэрэг, төрийн албан хаагч). Тодорхой бичнэ үү. |
| | **Төрийн бус этгээд** (Жишээ нь хагас цэрэгжсэн бүлэг, гэмт хэргийн бүлгэм, хувийн хамгаалалтын алба, аж ахуйн нэгжүүд) Тодорхой бичнэ үү: |
| | **Тодорхойгүй** (Өөрөөр хэлбэл халдлага үйлдэгч этгээдийг тогтоох, тодорхойлох боломжгүй). Тодорхой бичнэ үү: |
| | **Бусад** (Жишээ нь хамтрагч, гэр бүлийн гишүүн, итгэлтэй хүн) Тодорхой бичнэ үү: |

| | |
|---|---|
| 4. Энэ нөхцөл байдал хэзээ, яагаад үүссэн бэ? Энэ хүсэлтийг та эсвэл танай байгууллага гаргах болсон нөхцөл шалтгаан, үйл явдал юу вэ? | |

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

| | |
|---|---|
| 5. Эрүүл, аюулгүй байдал, хамгаалалтын төлөвлөгөө танд эсвэл танай байгууллага/сүлжээ/хүрээлэлд бий юу? (Энэ төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж буйг товч тайлбарлана уу.) | |

6. Учирч буй эрсдэл, заналхийллийг бууруулахын тулд таны санал болгож буй тодорхой үйл ажиллагааг сонгоно уу. Гэр бүл/хамтрагч тань үүнд хамаарах эсэхийг тодотгоно уу.

- ☐ Цахим аюулгүй байдал
- ☐ Нүүлгэн шилжүүлэлт, аврах ажиллагаа (жишээ нь тээврийн зардал, байрны түрээс, амьдрах зардал, эсвэл хамгаалагч болон, эсвэл түүний гэр бүлийг түр нүүлгэн шилжүүлэх)
- ☐ Гэр бүлээ дэмжих. Тодорхой тайлбарлана уу.
- ☐ Эрх зүйн туслалцаа
- ☐ Цагдан хоригдсон үеийн дэмжлэг
- ☐ Эрүүл мэндийн туслалцаа, үйлчилгээ
- ☐ Эрүүл амьдрал ба Өөрийгөө халамжлах (жишээ нь гэмтэл, сэтгэл зүйн үйлчилгээ)
- ☐ Хувийн болон/эсвэл хамтын эрүүл, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах
- ☐ Тээврийн аюулгүй байдал
- ☐ Харуул хамгаалалтын дэд бүтэц (тодруулбал хамгаалалтын камер, дохиоллын систем, хашаа, хаалга, цахим хамгаалалтын систем гэх мэт)
- ☐ Зэвсэггүй хамгаалалтын алба
- ☐ Бусад:

| | |
|---|---|
| 7. Эрүүл, аюулгүй байхад шаардлагатай, дээр дурдагдаагүй өөр хэрэгцээ шаардлагад санхүүжилт хүсэж байна уу?<br><br>ТИЙМ бол тайлбарлана уу.<br>ҮГҮЙ бол э | |

| | |
|---|---|
| 8. Санал болгож буй арга хэмжээг хэрэгжүүлэх цаг хугацаа юу вэ? | |
| 9. Эдгээр арга хэмжээг та эсвэл танай байгууллага/сүлжээ/хүрээлэл хэрхэн хэрэгжүүлэх вэ? | |
| 10. Санхүүжилт олгогдсон тохиолдолд ямар үр дүнг хүлээж байгаа вэ? (Хувь хүн, байгууллага эсвэл сүлжээ/хүрээллийн түвшинд ямар өөрчлөлт бий болох хүлээлттэй байгаа вэ?) | |

UAF A&P | Яаралтай ажиллагааны тэтгэлэг олгох хөтөлбөр

**ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЭТГЭЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

## IV. ХҮСЭЖ БУЙ САНХҮҮЖИЛТ

| | |
|---|---|
| 1. Хүсэж буй санхүүжилтийн хэмжээ. Валютын төрлөө тодорхой бичнэ үү. | |

2. Санхүүжилтийг хэрхэн ашиглах вэ? Доорх хүснэгтийг ашиглан төсвөө зүйл бүрээр жагсаана уу. **Жич: Ази, Номхон далайн ЯТС нь зөвхөн 5,000 ам. доллар хүртэлх санхүүжилт олгодог.**

| ТӨСВИЙН ЗҮЙЛ | Зардал<br>Валютын трл |
|---|---|
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |

| | |
|---|---|
| 3. Энэхүү санаачилга, үйл ажиллагаа нь Ази, Номхон далайн ЯТС-гаас санхүүжилт хүсэхээс гадна нь бусад ямар дэмжлэг авах боломжтой вэ? | |

## V. НУУЦЛАЛ

| | |
|---|---|
| Энэхүү хүсэлтийг та нууцлахыг хүсэж байна уу? | ◉ Тийм (Yes ○ Үгүй (No)<br>Хэрэв "Тийм" гэж хариулсан бол хувь хүний нэр, холбогдох хаягийг Ази, Номхон далайн ЯТС-гаас бусад этгээдэд ил болгохгүй. ***(Зөвшөөрөл олгох үйл явцын үед Ази, Номхон далайн ЯТС-гийн зөвлөх болох итгэлтэй хамтрагч нартай зөвлөлдөх шаардлагаас бусад үед).*** |